ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/78 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Барилгын тухай хуулийн 37, 38, 40 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа ИНЕГ/ХОТО/ХББ/Б-38/19 дугаар гэрээтэй Спорт цогцолборын барилгын ажилд захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн хамтарсан хяналт шалгалтыг хийж, барилгын ажил нь зураг төсөв, норм, стандартын дагуу хийгдэж байгаа эсэх болон зураг төсвөөс зөрүүтэй ажлын тоо хэмжээ, төсвийг нягтлан шалгаж, хяналтын нэгдсэн дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналт, шалгалтыг удирдамжид заасан хугацаанд багтаан гүйцэтгэж, дүгнэлт болон зураг төсвөөс зөрүүтэй ажлын тоо хэмжээ, төсөв, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлж, Иргэний нисэхийн үндэсний төвийн даргад танилцуулахыг ажлын хэсэг (С.Нацагдорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ААГУЙ
9020051071 Д. 6577539

1721 01 0734

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
A/78 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
9020051071 6577539

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	С.Нацагдорж	Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Х.Рэнцэнпил	Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны төсөвчин инженер
Гишүүд:	Г.Наранчимэг	Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын үйлчилгээний газрын мэргэжилтэн
	Б.Хүсэлт	Иргэний нисэхийн үндэсний төвийн Хуулийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн
	Б.Оюунчимэг	Иргэний нисэхийн үндэсний төвийн Худалдан авах ажиллагааны тасгийн ахлах инженер
	Ж.Билэгсайхан	Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуй, үйлчилгээний албаны барилгын хяналтын инженер
	С.Очирбат	“Татах хүч” ХХК-ийн ерөнхий архитектор
	Ц.Тэргэл	“Татах хүч” ХХК-ийн барилга бүтээцийн инженер
	Г.Хосбаяр	“ӨВМТХ” ХХК-ийн захирал
	Л.Мөнхзаяа	“ӨВМТХ” ХХК-ийн барилгын инженер
	Б.Норов	“ӨВМТХ” ХХК-ийн нягтлан бодогч

------ o0o ------

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
А/78 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
9020051071 ☎ 6577539

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

1. Зорилго:

1.1 Спорт цогцолборын барилгын ажилд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу Захиалагч, Зохиогч, Гүйцэтгэгчийн хамтарсан хяналт шалгалт хийх, барилгын ажил нь батлагдсан зураг төсөв норм, стандартын дагуу хийгдэж байгаа эсэх болон зөрүүтэй ажлын тоо хэмжээ, зураг төсвийг нягтлан шалгаж, хяналтын нэгдсэн дүгнэлт гаргах, барилгын ажлыг гүйцэтгэж дуусган, хүлээлгэн өгөх арга замыг талаар нэгдсэн санал боловсруулж, танилцуулах.

2. Хяналт, шалгалт хийх хугацаа:

2.1 Хамтарсан хяналт, шалгалтыг 2021 оны 4 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн ажлын тайланг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор удирдлагад танилцуулна.

3. Хяналт, шалгалтаар хийж гүйцэтгэх ажил:

3.1 Баригдсан барилга, байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдуулан “Барилгын тухай хууль”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, норм, дүрэм, стандартын дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах;

3.2 Спорт цогцолборын барилгын ажлын батлагдсан зураг төсөвт тусгагдаагүй, зайлшгүй хийх шаардлагын улмаас хийсэн магадлашгүй ажлын тоо хэмжээг гарган, төсвийг тооцох;

3.3 Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-н Захиалагчийн хяналтын инженерүүдийн хянаж гаргасан, батлагдсан зураг төсвөөс зөрүүтэй ажлын тоо хэмжээ болон түүний дагуу тооцсон магадлалаар батлагдаж ирсэн төсөвт тусгагдаагүй ажлын зөрүү төсвийг тооцох;

3.4 Спорт цогцолборын барилгын гадна инженерийн шугам сүлжээний ИНЕГ/ХО/ТО/01/03 дугаартай гэрээт ажилтай уялдан хүлээгдэж байгаа барилгын гадна тохижилтын ажлын төлөвлөлтийг баталж, ажлыг яаралтай эхлүүлэн барилгын ажлын гэрээт хугацаанд багтаан гүйцэтгүүлэх;

-------- o O o ---------